

**ГОВЬ ХК-ИЙН 2023 ОНЫ 1-Р УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 03-р сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Монгол: gobi.mn Европ: gobicashmere.com Америк: gobicashmere.com/us Их Британи: gobicashmere.com/uk Хятад: gobicashmere.cn	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500	
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Ц.Оргилболд /Тэргүүн дэд захирал/	
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	1-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав. /Хавсралт-1/
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	
	Мөнгөн гүйлгээний тайлан	

2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт																				
	Эрсдэл, аудитын хорооны шийдвэрийг хамт хавсаргав. /Хавсралт-2/																				
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																				
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table><tr><th>Үзүүлэлт</th><th>2022.03.31</th><th>2023.03.31</th></tr><tr><td>Бохир ашгийн маржин</td><td>47%</td><td>53%</td></tr><tr><td>Цэвэр ашгийн маржин</td><td>-28%</td><td>-7%</td></tr><tr><td>Эргэлтийн харьцаа</td><td>0.8</td><td>0.9</td></tr><tr><td>Бараа материалын эргэц</td><td>664</td><td>488</td></tr><tr><td>Хувьцааны нэгж үнэ /₮/</td><td>290</td><td>250</td></tr></table>		Үзүүлэлт	2022.03.31	2023.03.31	Бохир ашгийн маржин	47%	53%	Цэвэр ашгийн маржин	-28%	-7%	Эргэлтийн харьцаа	0.8	0.9	Бараа материалын эргэц	664	488	Хувьцааны нэгж үнэ /₮/	290	250
Үзүүлэлт	2022.03.31	2023.03.31																			
Бохир ашгийн маржин	47%	53%																			
Цэвэр ашгийн маржин	-28%	-7%																			
Эргэлтийн харьцаа	0.8	0.9																			
Бараа материалын эргэц	664	488																			
Хувьцааны нэгж үнэ /₮/	290	250																			
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт																				
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	- Цар тахлын нөлөөлөл дэлхий даяар буурч, Хятад улс хилээ нээсэн зэрэг гадаад орчны нөхцөл байдал өнгөрсөн оноос сайжирсан нь компанийн дотоод болон гадаад зах зээлийн борлуулалтад эерэг нөлөөтэй байна. 2023 оны 1-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад дотоодын зах зээлийн борлуулалт 70%-иар өссөн. - Говьбрэндийн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд таниулах зорилгын хүрээнд олон улсад онлайн худалдааны сувгуудаа сайжруулж, маркетинг идэвхжүүлэлтийн ажлуудыг тасралтгүй хийсээр байгаа билээ. Үүний үр дүнд Говь брэндийн танигдалт нэмэгдсээр байгаа бөгөөд шинэ харилцагчийг татах зардал өнгөрсөн оны мөн үеэс 6.7 дахин буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт онлайн борлуулалт 47% өссөн байна. 2023 оны 1-р улирлын байдлаар Европ, АНУ, Хятадын зах зээл дээрх борлуулалт 33%, 65%, 18% -иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. - Өнгөрсөн оны сүүлээс эхлэн Италийн алдарт дизайнер Giorgio Spina Говь Брэндийн ерөнхий дизайнераар ажиллаж эхэлсэн бөгөөд дизайн хөгжүүлэлтийн багийнхан цоо шинэ өнгө төрхтэй загварын хөгжүүлэлт дээр хамтран ажиллаж байна.																			
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.																			
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																				

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2022.03.31	2023.03.31
Холбоотой талд өгсөн санхүүжилт	30,927,360	18,950,000
Холбоотой талаас авсан санхүүжилт	60,277,483	18,950,000
Холбоотой талтай хийсэн борлуулалт	27,746	52,157
Холбоотой талаас авсан худалдан авалт	297,183	507,420
Хүүгийн орлого	-	195,185
Хүүгийн зардал	1,062,539	607,149
Түрээсийн орлого	69,693	56,053
Түрээсийн зардал	209,911	190,828


Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно.

5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

23,186

/2023.03.31-ний байдлаар/

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь
Таван Богд Трейд ХХК	392,640,072	50.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%

2023.03.31-ний байдлаар нийт 23,186 хувьцаа эзэмшигчидтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь Таван Богд Трейд ХХК болон Хиде Интер ХХК бөгөөд тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ-ийн хараат бус гишүүд



Дамбын ГЭРЭЛМАА
ТУЗ-ийн дарга, Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



Дамбийжавын ХҮРЭЛБААТАР
Нэр дэвшүүлэх хорооны дарга

Тэтгэвэрт гарсан



Мягмарын БАЯР
Эрсдэл, аудитын хорооны дарга

ШУТИС-ийн UTC-ийн Хөнгөн Үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын дэд профессор



Алтангэрэлийн ЖАРГАЛМАА
Эрсдэл, аудитын хорооны гишүүн

GAPE, ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч



Такэши КАМБЭ
Цалин урамшууллын хорооны гишүүн

Япон улсын Asahi Life Insurance компанийн менежер

ТУЗ-ийн ердийн гишүүд




Цагаачийн БААТАРСАЙХАН
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



Дашдаваагийн ХУЛАН
Эрсдэл, аудитын хорооны гишүүн

Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч



Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ
Цалин урамшууллын хорооны гишүүн

Таван Богд Группийн Маркетингийн газрын захирал




Хидэо САВАДА

Япон улсын H.I.S компанийн Ерөнхийлөгч

	ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД ТУЗ-ийн дэргэд Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал хоёр сар тутам, Эрсдэл аудитын хороо улирал тутам, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороо хагас жил тутам ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн гишүүдийн зүгээс өөрсдийн эрх үүргийн хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУЗ-ийн зүгээс жил бүр компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж МХБ болон өөрийн веб хуудсаар дамжуулан тайлагнадаг бөгөөд ТУЗ-ийн өөрийн үнэлгээг дотооддоо тогтмол хийн үйл ажиллагаагаа дүгнэн сайжруулдаг. Говь ХК нь сайн засаглалын туршлагаа суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт асуулт бүрд дор бүр нь хариу өгч ажилладаг.
7.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i>
	ХУРАЛ • ТУЗ-ийн ээлжит хурлыг 2023.02.03, 2023.03.10-ны өдөр, ээлжит бус хурлыг 2023.03.06, 2023.03.20-ны өдрүүдэд; • Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурлыг 2023.01.16-ны өдөр, ээлжит бус хурлыг 2023.02.27-ны өдрүүдэд; • Цалин урамшууллын хорооны ээлжит хурлыг 2023.01.16-ны өдөр; • Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурлыг 2023.03.30-ны өдөр тус тус зохион байгуулсан. ТОГТООЛ, ШИЙДВЭР Тайлант хугацаанд нийт 16 тогтоолыг баталсан. Үүнд: • ТУЗ-өөс нийт 12 тогтоол (дотоод үйл ажиллагаатай холбоотой 10 тогтоол, санхүүжилттэй холбоотой 2 тогтоол) • Нэр дэвшүүлэх хорооноос 2 тогтоол, • Эрсдэл, аудитын хорооноос 2 тогтоол. Мөн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаас нийт 34 шийдвэр, 13 санал зөвлөмж, 7 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ 1-р улирлын байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан. • 2022 оны Жилийн үйл ажиллагааны тайлан; • 2022 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт; • 2022 оны Компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлан; • 2022 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан; • 2022 оны Тогтвортой хөгжлийн тайлан; Мөн мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд info.gobi.mn компанийн веб хуудсын агуулга, дизайныг шинэчлэн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт зориулсан цэсийг сайжруулсан. Манай компани цахим хуудсаараа дамжуулан хувьцаа эзэмшигчдээ тогтмол мэдээллээр ханган ажилладаг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн асуулт, санал хүсэлттэй холбоотой дуудлага, и-мэйлд дор бүр нь хариу өгч ажиллаж байна. НОГДОЛ АШИГ Говь ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2-р сарын 3-ны өдрийн №2 тоот тогтоолын дагуу компанийн 2022 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

ХУВЬЦААНЫ ХАНШ

Үзүүлэлт	2022.12.31	2023.03.31	Өсөлт, бууралт
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /шир/	780,112,500	780,112,500	энгийн хувьцаа
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/			
Хаалтын үнэ	248.32	250.19	0.8%
Хамгийн их үнэ	311.50	269.37	-13.5%
Хамгийн бага үнэ	242.73	245.01	0.9%
Дундаж үнэ	272.19	254.17	-6.6%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/			
Хамгийн их /өдөрт/	1,234,986	460,525	-62.7%
Хамгийн бага /өдөрт/	392	253	-35.5%
Дундаж /өдөрт/	30,702	39,326	28.1%
Нийт	7,552,604	2,398,898	-68.2%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/			
Хамгийн их /өдөрт/	336,411,123	116,217,538	-65.5%
Хамгийн бага /өдөрт/	107,018	67,355	-37.1%
Дундаж /өдөрт/	8,519,435	9,898,255	16.2%
Нийт	2,095,780,903	603,793,544	-71.2%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/	193,717,536,000	195,176,346,375	0.8%




БУСАД

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах хөтөлбөрийг 2022 оны 11-р сард баталсан бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:


- Компанийн хэмжээнд 2020 оноос хойш бодлогын чанартай баримт бичгүүд олноор шинэчлэн батлагдсан учир эдгээр бодлогуудтай уялдуулж Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэх төслийг Эрсдэл аудитын хорооны хурлаар хэлэлцэн, 2-р сарын 3-ны ТУЗ-ийн хурлаар шинэчлэн баталсан.
- Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлого, ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг шинээр боловсруулан, Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн, 2-р сарын 3-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.
- ТУЗ-ийн гишүүдтэй байгуулах санамж бичиг болон Нууц хадгалах гэрээний загварыг 1-р сарын 16-ны Нэр дэвшүүлэх хорооны хурлаар баталсан.

8. *Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл*

БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР (тэрбум төгрөг, %)



САНХҮҮГИЙН ҮР ДҮН

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
		2022.03.31	2023.03.31	тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	<i>сая.төг</i>	25,634	41,108	15,474	60%
Үүнээс: Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	14,356	24,343	9,987	70%
Экспортын борлуулалт	<i>сая.төг</i>	2,653	4,075	1,423	54%
Онлайн борлуулалт	<i>сая.төг</i>	8,626	12,690	4,064	47%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	<i>мян.шир</i>	129	162	33	26%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	<i>сая.төг</i>	13,516	19,267	5,751	43%
НИЙТ АШИГ	<i>сая.төг</i>	12,118	21,841	9,723	80%
Бохир ашгийн хувь	<i>хувь</i>	47%	53%		6%
Үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	18,562	24,309	5,747	31%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	<i>сая.төг</i>	(6,444)	(2,468)	3,977	62%
Үйл ажиллагааны ашгийн хувь	<i>хувь</i>	-25%	-6%		19%
Үйл ажиллагааны бус зардал	<i>сая.төг</i>	911	253	(658)	-72%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	(7,355)	(2,721)	4,634	63%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	<i>сая.төг</i>	(7,162)	(3,081)	4,081	57%
Цэвэр ашгийн хувь	<i>хувь</i>	-28%	-7%		20%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	32,078	43,576	11,497	36%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	<i>төгрөг</i>	1.25	1.06	(0.19)	-15%
ҮЙЛДВЭРЛЭЛ					
Сүлжмэл бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	143	155	12	8%
Нэхмэл бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	25	56	31	127%
Оёмол бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	10	8	-2	-15%
Пальто	<i>мян.шир</i>	3	4	1	40%
Пиджак	<i>мян.шир</i>	1	1	0	35%
Ээрмэл утас	<i>тонн</i>	32	49	18	56%
АЖИЛТНУУДЫН ТОО	<i>хүн</i>	1,561	1,528	(33)	-2%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>мян.төг</i>	16,421	26,903	10,482	64%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	<i>сая.төг</i>	202	602	401	199%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<i>сая.төг</i>	275,430	317,432	42,002	15%
Үүнээс: Банкны зээл	<i>сая.төг</i>	202,674	265,437	62,763	31%
НИЙТ ХӨРӨНГӨ	<i>сая.төг</i>	296,119	319,176	23,057	8%
Үүнээс: Бараа материал	<i>сая.төг</i>	137,402	139,521	2,120	2%
МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ	<i>сая.төг</i>	4,871	5,657	786	16%
Үүнээс: Онлайны маркетинг	<i>сая.төг</i>	4,718	5,389	671	14%

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

№	Санхүүжүүлэгчийн нэр	Санхүүжилтийн хэлбэр	Жилийн хүүгийн хувь	Валют	Зээлийн үлдэгдэл 2022.12.31	Зээлийн үлдэгдэл 2023.03.31
1	Голомт банк	Урт хугацаат зээл	11%	MNT	20,000,000	20,000,000
2	Голомт банк	Зээлийн шугам	13.5%	MNT	-	52,721,928
3	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1А)	Богино хугацаат зээл	6.79%	USD	6,262,909	5,120,975
4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1Б)	Богино хугацаат зээл	7.49%	USD	9,394,364	7,681,462
5	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 2)	Богино хугацаат зээл	6.93%	USD	11,273,237	9,601,827
6	Хаан банк (Зээлийн шугам) (iii)	Урт хугацаат зээл	3%	MNT	10,000,000	10,000,000
7	Монгол Улсын Хөгжлийн Банк (iv)	Богино хугацаат зээл	12%	MNT	42,900,000	42,900,000
8	Монгол Улсын Хөгжлийн Банк (iv)	Богино хугацаат зээл	11.5% (3%)	MNT	33,333,333	33,333,333
9	Хас банк (Зээлийн шугам) (v)	Зээлийн шугам	15.6%	MNT	9,566,000	-
10	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (vii)	Урт хугацаат зээл	4.25%	EUR	29,352,160	30,573,520
11	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (vii)	Урт хугацаат зээл	5.25%	EUR	51,366,280	53,503,660
Нийт зээлийн дүн					223,448,283	265,436,704

Монгол банкны ханш /төг/:
 USD 3,444.60
 EUR 3,669.02

2022-12-31
 3,444.60
 3,669.02

2023-03-31
 3,520.67
 3,821.69

ХҮНИЙ НӨӨЦ



ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛ



Галлериа салбар болон Төв дэлгүүр дээр мэргэжлийн стилистийн зөвлөх үйлчилгээг шинээр нэвтрүүлэн хэрэглэгчид стилистийн үйлчилгээг үзүүлж байна.



Төрийн соёрхолт С.Саранцацралт зураачтай хамтран “Тэргүүлэгч цэцэг яргуй” цагаан сарын коллекцийг амжилттай гаргасан нь хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн өндөр үнэлгээг авсан.

Жуулчдын борлуулалт




2023 оны 1-р улирлын байдлаар дотоодын зах зээлийн нийт борлуулалт 70%-р өссөн бөгөөд үүний 12%-ийг жуулчдын борлуулалт эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад жуулчдын борлуулалт 14.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.


ЭКСПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ

Экспортын зах зээлийн хувьд манай компани цөөн, чанартай харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж байгаа бөгөөд 2023 оны 1-р улирлын байдлаар 18 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.

ОНЛАЙН ЗАХ ЗЭЭЛ




SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах ажлуудыг хийж байна. Үр дүнд нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад органик түлхүүр үгсийн зэрэглэл 3.7 дахин сайжирсан үр дүнтэй байна.



Instagram-ийн албан ёсны таних тэмдгийг Америк, Их Британи, Герман улсын хаяг дээр нэмж авсан. Энэхүү албан ёсны таних тэмдэг нь зөвхөн баталгаажсан, албан шалгууруудыг давсан брэндүүд болон хэрэглэгчдэд олгогддог ороо онцлог юм.



Data Science

Хэрэглэж буй Систем



Гадаад борлуулалтын газар нь хэрэглэгчдийн нэгдсэн дата бааз байхгүй байсан учир цуглаж буй датаг бүрэн хэмжээнд ашиглахад боломж хангалтгүй байсан тул 2023 оноос эхлэн Data Science ашиглаж эхэлсэн. Ингэснээр худалдан авалтын замналыг тодорхойлон мэдээллийн нэгдсэн дата платформтой болж, дата боловсруулалтыг хийн, борлуулалтын таамаглалыг илүү бодитой гаргадаг болох ажлуудыг амжилттай хийж байна.

Харилцагчийн үзүүлэлт



2023 оны 2-р сард Salesforce болон Mirum компаниудтай хамтран харилцагчийн датанд аудит оруулсан. E-mail хаяггүй, давхардан бүртгүүлсэн хэрэглэгчдийн датаг цэгцэлж, идэвхгүй хэрэглэгчдийн мэдээллийг цэвэрлэснээр дата багтаамж суларч, чанартай, урт хугацааны харилцагч нар үлдсэн. Аудит орсны дараа 2023.03.31-ний байдлаар нийт 362,676 харилцагч бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7 дахин өсөлттэй байна.

Нэг харилцагчийг татах зардал 2022 оны 1-р улиралд €92.2 байсан ба 2023 онд €13.6 болж 6.7 дахин буурсан үзүүлэлттэй байна.

ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТ



PLM буюу Product Lifecycle Management системийн нэвтрүүлэлтийн нэг, хоёрдугаар үе шатыг амжилттай хэрэгжүүлэв. Энэхүү системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр бүтээгдэхүүний эх сурвалжийг бүрэлдэхүүн тус бүрээр нь тогтоох, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг үр бүтээмжтэй хийх, өртөг тооцооллыг бүрэн автоматжуулах, бараа материалын эргэцийн удирдлагыг сайжруулах зэрэг олон боломжийг бүрдүүлэх юм.

ЗАГВАР, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



Говь брэндийн ерөнхий дизайнераар Италийн алдарт дизайнер Giorgio Spina ажиллан шинэ загварын хөгжүүлэлтүүдийг хийж байгаа бөгөөд 2-р улиралд шинэ коллекц гаргах бэлтгэлээ ханган ажиллаж байна.



Гутлын зориулалттай 100% ноолууран “FELTON” драпыг шинээр гарган ноолууран гутал хөгжүүлэлт дээр ажиллаж байна.

КОЛЛЕКЦУУД



Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Баатарсайхан - 2

Албан тушаал: “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Овог, нэр:

Албан тушаал: “...” Аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2023.04.19



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОН
ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2023 оны 03 сарын 31

(мян.төгрөг)

	2023.03.31	2022.12.31
Борлуулалтын орлого	41,108,028	193,427,609
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(19,266,993)	(97,766,831)
Нийт ашиг	21,841,035	95,660,778
Бусад орлого	156,145	1,162,425
Борлуулалт ба маркетингийн зардал	(14,563,450)	(61,767,484)
Ерөнхий ба удирдлагын зардал	(4,025,431)	(14,138,399)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	0	49,464
Бусад зардал	0	(13,355)
Санхүүгийн орлого	200,587	29,261
Санхүүгийн зардал	(6,329,952)	(30,979,282)
Татварын өмнөх алдагдал	(2,721,067)	(9,996,592)
Орлогын татварын өгөөж (зардал)	-360,277	2,998,982
Тайлант жилийн цэвэр алдагдал	(3,081,344)	(6,997,610)
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл		(4,301,861)
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	(333,952)	(11,997,888)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого	(333,952)	(16,299,749)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	(3,415,296)	(23,297,359)

(мян.төгрөг)

	2023.03.31	2022.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	22,985,637	9,034,919
Дансны ба бусад авлага	3,266,848	3,318,986
Урьдчилгаа төлбөр	6,547,989	2,318,495
Бараа материал	139,504,219	128,791,463
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	17,227	17,227
	172,321,919	143,481,090
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	135,650,093	137,432,575
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	528,411	731,724
Хойшлогдсон татварын хөрөнгө	14,549,806	14,879,483
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	1,151,084	1,587,295
	151,879,393	154,631,077
Нийт хөрөнгийн дүн	324,201,313	298,112,167
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны ба бусад өглөг	9,219,651	20,969,192
Гэрээний өр төлбөр	2,908,638	1,983,898
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	26,503	26,503
Богино хугацаат түрээсийн өглөг	558,659	777,988
Орлогын албан татварын өглөг	1,777,907	3,683,126
Богино хугацаат зээл	173,419,610	129,853,617
	187,910,969	157,294,324
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат түрээсийн өглөг	79,810	112,069
Урт хугацаат зээл	93,922,117	95,686,234
Бусад урт хугацаат өглөг	31,669,114	30,984,941
Хойшлогдсон татварын өглөг	8,206,834	8,206,834
	133,877,875	134,990,078
Нийт өр төлбөрийн дүн	321,788,844	292,284,402
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	44,568,540	44,568,540
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(11,769,962)	(11,436,010)
Хуримтлагдсан алдагдал	(31,166,222)	(28,084,878)
	2,412,469	5,827,765
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	324,201,313	298,112,167

(мян.төгрөг)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	48,870,401	561,878	(21,087,268)	29,125,124
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,997,610)	(6,997,610)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	(4,301,861)	(11,997,888)	-	(16,299,749)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(4,301,861)	(11,997,888)	(6,997,610)	(23,297,359)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(11,436,010)	(28,084,878)	5,827,765
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(3,081,344)	(3,081,344)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		0	(333,952)	-	(333,952)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	0	(333,952)	(3,081,344)	(3,415,296)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2023 оны 03 сарын 31-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(11,769,962)	(31,166,223)	2,412,469

(мян.төгрөг)

	2023.03.31	2022.12.31
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(22,744,136)	45,908,164
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,431,217)	(3,124,091)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	38,459,981	(26,140,862)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	14,284,628	16,643,211
Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү	(333,952)	(11,997,888)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	41	117
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,034,919	4,389,479
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,985,637	9,034,919



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г 2023 оны 1-р улирлын санхүүгийн
тайланг дүгнэх тухай Т

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2023 оны 1-р улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь үнэн зөв тайлагнагдсан болохыг баталсугай.
2. 1-р улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх

Эрсдэл, аудитын хорооны дарга

Гишүүд



М.БАЯР

Д.ХУЛАН

А.ЖАРГАЛМАА